

**ОРХОН АЙМАГ, “ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ИЙН  
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024 оны 02 дугаар сарын 28 өдөр

№ 03/24

Орхон аймаг

Энэхүү гэрээг нэг талаас Орхон аймгийг төлөөлж Орхон аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал /цаашид гэрээний тал гэх/ нөгөө талаас “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Мөнхбаатар /цаашид гэрээний тал гэх/ нар Засгийн газрын болон Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн хөгжлийн чиг хандлагын хүрээнд 2024-2026 онд хамтран ажиллах зорилгоор харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2 дахь заалт, Гамшгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар тогтоол энэхүү гэрээний нийтлэг үндэслэл болно.

1.2. Энэхүү гэрээ нь “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн болон орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, энэхүү төсөл хөтөлбөр нь орон нутгийн иргэдийн эрх ашгийг дэмжсэн, орон нутгийн хөгжилд хувь нэмэр болохуйц, үр дүнг нь тооцох боломжтой байх зарчимд тулгуурлан хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Гэрээний талууд тэгш, шударга ёсны зарчмыг үндэслэн үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

1.4. Газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл эрхэлж, олсон орлогоос орон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй аливаа төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, орон нутгийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд “Зэс эрдэнийн хувь” ХХК-иас оруулж буй үнэтэй хувь нэмэр гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна.

1.5. Гэрээний нийт мөнгөн хөрөнгө нь гэрээний хүрээнд хамаарах бүх ажил, үйлчилгээ (Аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, бүтээн байгуулалт, энэ чиглэлийн төсөл хөтөлбөр)-г хэрэгжүүлж гэрээний бүх болзлыг бүрэн хангасан баталгаа тул “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийг энэхүү гэрээтэй холбоотой аливаа гомдол, нэхэмжлэл, шаардлага, тэдгээрийн үндэслэлээс ангид байлгана.

**Хоёр. Аймгийн Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Энэхүү гэрээний хүрээнд аймгийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.



2.1.1.Гэрээний 3.1.3-д заасан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн хүрээнд захиран зарцуулах,

2.1.2.Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийг хангах,

2.1.3.“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах талаар хамтран ажиллах, гэм хорыг арилгуулах талаар шаардлага тавих,

2.1.4.“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж хариу өгөх,

2.1.5.“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн үйлдвэрлэлийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хуулийн хүрээнд туслалцаа үзүүлэх, хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

2.1.6.“Зэс эрдэнийн хувь” ХХК-аас аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, бүтээн байгуулалт зэрэг арга хэмжээ, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор олгож буй мөнгөн хөрөнгийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор нийтэд мэдээлнэ.

Гурав. **“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн эрх, үүрэг**

3.1.Энэхүү гэрээний хүрээнд “Зэс эрдэнийн хувь” ХХК нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2.Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиглэлийг өөрийн үйл ажиллагааны бодлогод нийцүүлэн сонгох;

3.1.3.Тухайн жилийн улс орны эдийн засгийн нөхцөл байдал, зэсийн үнийн түвшин, ТӨБЗГ-аас баталсан бизнес төлөвлөгөө, үйлдвэрийн газрын орлого, ашгийн төлөвлөгөөний биелэлт зэргийг харгалзан “Зэс эрдэнийн хувь” ХХК-иас орон нутагт жилд 100,000,000.00 (нэг зуун сая) доошгүй төгрөгийн мөнгөн хөрөнгийг аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, бүтээн байгуулалт, энэ чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор жил бүр хөрөнгө оруулна.

3.1.4.Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийг сар бүр төлж, жилийн эцэст тооцоо нийлэн хянан баталгаажуулах,

3.1.5.Хуулийн хүрээнд үйлдвэрийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх,

3.1.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй, зохих шаардлагыг хангасан татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;

3.1.7. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

Дөрөв. **Хамтын ажиллагааны хороо**

4.1. Талуудын гэрээ байгуулах явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г аймгийн Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж, ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангаж, Баянцагаан багийн Иргэдийн Нийтийн Хурлаас нэг иргэнийг дэвшүүлэн, хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо нь жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор дараа жил хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гарган, гэрээ байгуулагч талуудад хүргүүлнэ.

Тав. **Гэрээний хэрэгжилт**

5.1. Энэхүү гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх, гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын албан ёсны вэб хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна.

5.2. Талууд жил бүрийн хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах бөгөөд төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байна.

5.3. Төлөвлөгөөний биелэлтийг талуудын ажлын хэсэг дүгнэн үр дүнг дараа оны 02 дүгээр сарын 15-ны дотор тайлагнана.

Зургаа. **Маргаан шийдвэрлэх**

6.1. Талуудын аливаа санал зөрөлдөөн, маргаан гарсан тохиолдолд асуудлыг аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. **Гэрээ хүчин төгөлдөр болох**

7.1. Талуудын гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр байна.

7.2. Хуульд заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

7.3. Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй нэг хэсэг болно. Талууд бичгээр үйлдэж, гарын үсэг зураагүй бол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй бөгөөд бичгээр үйлдэж, гарын үсэг зураагүй нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр бус байна.

Найм. Бусад зүйл

8.1.Талууд энэхүү гэрээний дагуу талуудын хяналтаас гадуур дайн, ажил хаялт, байгалийн гамшиг, засгийн газрын арга хэмжээ, гал түймэр, цар тахал, аливаа төмөр замын хориг (тодорхой чиглэлд ачаа тээвэрлэхийг түр зогсоосон төмөр замын хэлтсүүдийн тушаал) гэх мэт давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас тухайн тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад болж байгаа бол энэхүү Гэрээг бүрэн буюу хэсэгчилсэн биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй ба энэхүү гэрээний хэрэгжилтийг холбогдох хугацаагаар сунгана.

Ес. Гэрээ байгуулсан талуудын хаяг:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар  
Хаяг: 61033, Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Уртбулаг баг - А.Амарын талбай,  
Нутгийн удирдлагын ордон  
Утас:70355590, Факс:70352621

"Зэс Эрдэнийн хувь" ХХК  
Хаяг: 61027, Орхон аймаг, Баян-Өндөр  
сум, 11-р хороолол Цагаанчулуут баг,  
Спорт цогцолбор  
Утас:976-95000429, 976-99115879

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ М.ТҮМЭНЖАРГАЛ

"ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ" ХХК ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Б.МӨНХБААТАР

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ш.ГАНБОЛД

"ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ" ХХК-ИЙН  
САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН  
ДЭД ЗАХИРАЛ Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА М.МӨНХБАЯР

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА С.ДАВААДОРЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.АЛСАНСАЙНХУВЬТ